



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хар-Ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2024/209/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Эвиденсе аудит ХХК-ийн захирал: С.Бадамгарав
Улаанбаатар хот	Утас: 99057121 Цахим хаяг: info@evidenceaudit.mn
2024 он	Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
	Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
	Аудитор: Т.Болортуяа
	Утас: 99017537 Цахим хаяг: Bolortuya@evidenceaudit.mn
	Аудиторын туслах: М.Отгонням
	Утас: 85222519 Цахим хаяг: Otgonnyam@evidenceaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

**ХАР-УС НУУР ОРЧМЫН УЛСЫН ТУСГАЙ
ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ ДАРГА
Б.ГАНЗОРИГ ТАНАА**

2024.02.24 № 1/102
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хар-Ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хар-Ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дотоод албан томилолтын зардлыг 536.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 420.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт 24 арга хэмжээ

дэвшүүлсэн. Гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө 91 хувьтай үнэлүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

Нэг . Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мян. төгрөг/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	27,065.17	11,166.52
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	491,254.76	528,094.39
	Нийт хөрөнгийн дүн	518,319.93	539,260.91
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	518,319.93	539,260.91
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	518,319.93	539,260.91
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	517,455.70	858,740.91
	Үйл ажиллагааны зардлын дүн	564,853.88	818,578.68
	Үйл ажиллагааны үр дүн	(47,398.18)	40,162.23
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	(19,221.25)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(47,398.18)	20,940.97
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	518,319.93	518,319.93
	Тайлант оны үр дүн	-	20,940.97
	Эцсийн үлдэгдэл	518,319.93	539,260.91
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	443,801.80	753,326.19
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	443,801.80	753,326.19
	Үйл ажиллагааны ЦМГ		
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		Төлөвлөгөө	
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	737,052.50	753,326.19
	Урсгал зардал	737,052.50	753,326.19
	Хөрөнгийн зардал	-	-
	Эргэж төлөгдөх зээл	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	732,252.50	649,160.99
	Улсын төсвөөс санхүүжих	732,252.50	628,087.30
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	15,823.69
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	5,250.00
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих /бусад/		
	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

Хоёр . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 22,515.3 мянган төгрөгийн алдаа¹ зөрчил илэрснээс 22,515.3 мянган төгрөгийн зөвлөмж өглөө. Үүнд:

Хар-Ус нуур орчмын УТХГНХЗ-ын өмч болох байранд байрлах төсөвт байгууллагууд өрөө тасалгааны түрээсийн төлбөрийг тухайн байгууллагаар төлүүлсэн байна.

3.1 Зөвлөмж

3.1.1 Түрээсийн төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Хар-Ус нуур орчмын УТХГНХЗ-ын өмч болох байранд байрлах ХУНБЦГ, БОАЖГ, ХНХГСГЗ, Ой анги зэрэг эдгээр төсөвт байгууллага өрөө тасалгааны түрээсийн төлбөрийг тухайн байгууллагаар төлүүлсэн байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хянах зэрэг заалтуудад нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тухайн байгууллагуудаар түрээсийн төлбөрийг нөхөн төлүүлж улсын төсөвт төвлөрүүлэх.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Хар-Ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа	Хар-Ус нуур орчмын УТХГНХЗ-ын өмч болох байранд байрлах ХУНБЦГ, БОАЖГ, ХНХГСГЗ, Ой анги зэрэг эдгээр төсөвт байгууллага өрөө тасалгааны түрээсийн төлбөрийг тухайн байгууллагаар төлүүлсэн байна.	1	22,515.3					1	22,515.3		
Нийт дүн		1	22,515.3	-	-	-	-	1	22,515.3	-	-

ДӨРӨВ. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Үүнээс: Аудит хийсэн хэлбэр		

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

		Аудитад хамрагдах	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	1	1			1			
	Нийт	1	1			1			